

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/10/НА-СТА-ОНТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Завсрын аудитын талаар	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	14
5.3 Зөвлөмж	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЖДҮҮЭ	Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ШАРЫН ГОЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА М.МӨНХБАЯР
ТАНАА

2025.02.25 № А5

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд “Шинэ хоршоо хөдөлгөөн” арга хэмжээний хүрээнд тус суманд 5 хоршоо байгуулагдсанаас сумын газар нутагт 2 хоршоо үйл ажиллагаагаа хэрэгжүүлж эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Шалгуур хангасан хоршоод орж ирээгүй зээл олгогдоогүй байна. Мөн өмнөх оны үлдэгдэл 130,110.7 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлт 108,476.2 мянган төгрөг хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 1,070.7 мянган төгрөгийг зарцуулж 237,516.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 94.3 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/


Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	435,376,022.65	441,436,753.03
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	130,110,766.34	237,516,212.65
312	Банкинд байгаа	130,110,766.34	237,516,212.65
3121	Төгрөг	130,110,766.34	237,516,212.65
31211	Төрийн сангийн харилцах	130,110,766.34	237,516,212.65
33	АВЛАГА	305,265,256.31	203,920,540.38
334	Зээлийн хүүгийн авлага	4,524,093.72	2,878,121.19
335	Бусад авлага	300,741,162.59	201,042,419.19
331	Ажиллагчидтай холбоотой авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	300,741,162.59	201,042,419.19
35	БАРАА МАТЕРИАЛ		
351	Түүхий эд материал		
354	Хангамжийн материал		
35410	Бичиг хэргийн материал		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
392	Биет хөрөнгийн дүн		
39201	Барилга байгууламж		
39202	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	435,376,022.65	441,436,753.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,703,234.46	1,703,234.46
41	Богино хугацаат өр төлбөр	1,703,234.46	1,703,234.46
413	Өглөг	1,703,234.46	1,703,234.46
4136	Бусад өглөг	1,703,234.46	1,703,234.46
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,703,234.46	1,703,234.46
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	433,672,788.19	439,733,518.57
51	Засгийн газрын хувь оролцоо	433,672,788.19	439,733,518.57
511	Засгийн газрын оруулсан капитал		
51101	Орон нутгийн төсвийн оруулсан		
512	Хуримтлагдсан үр дүн	433,672,788.19	439,733,518.57
51210	Өмнөх үеийн үр дүн	423,610,454.91	433,672,788.19
51220	Тайлант үеийн үр дүн	10,062,333.28	6,060,730.38
51300	Дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	435,376,022.65	441,436,753.03

XTO5430@1012203

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	10,722,333.28	7,131,480.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,722,333.28	7,131,480.38
120	Нийтлэг татварын бус орлого	10,722,333.28	7,131,480.38
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,722,333.28	7,131,480.38
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,722,333.28	7,131,480.38
2	Үйл ажиллагааны зардал	660,000.00	1,070,750.00
21	Урсгал зардал	660,000.00	1,070,750.00
210	Бараа, үйлчилгээний зардал	660,000.00	1,070,750.00
2104	Хангамж, бараа материалын зардал		260,750.00
210401	Бичиг хэргийн зардал		118,700.00
210402	Тээвэр шатахуун		142,050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	-	810,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		810,000.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	660,000.00	
3	Үйл ажиллагааны үр дүн	10,062,333.28	6,060,730.38
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
2250011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	10,062,333.28	6,060,730.38



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	151,130,188.00	108,476,196.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,130,188.00	108,476,196.31
120	Нийтлэг татварын бус орлого	151,130,188.00	108,476,196.31
120002	Хүүгийн орлого		
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	151,130,188.00	108,476,196.31
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	660,000.00	1,070,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	660,000.00	1,070,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	660,000.00	1,070,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	-	810,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		810,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	660,000.00	
210901	Бараа ажил үйлчилгээний зардал		260,750.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	150,470,188.00	107,405,446.31
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	204,940,000.00	-
230001	Эргэж төлөгдөх зээл	204,940,000.00	
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(204,940,000.00)	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(54,469,812.00)	107,405,446.31
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		130,110,766.34
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	130,110,766.34	237,516,212.65



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	259,006,400.00	1,070,750.00	(257,935,650.00)	0.4
21	Урсгал зардлын дүн	5,000,000.00	1,070,750.00	(3,929,250.00)	21.4
210	Бараа үйлчилгээний зардал	5,000,000.00	1,070,750.00	(3,929,250.00)	21.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	950,000.00	810,000.00	(140,000.00)	85.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	950,000.00	810,000.00	(140,000.00)	85.3
210901	Бараа үйлчилгээний зардал	4,050,000.00	260,750.00	(3,789,250.00)	6.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	254,006,400.00	-	(254,006,400.00)	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	254,006,400.00		(254,006,400.00)	0.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	259,006,400.00	108,476,196.31	(150,530,203.69)	41.9
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого	254,006,400.00	108,476,196.31	(145,530,203.69)	42.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00		(5,000,000.00)	
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих			-	-
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		130,110,766.34	130,110,766.34	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		237,516,212.65	237,516,212.65	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан нь эрхэм зорилгоо “сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Тус байгууллага нь сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг төрөөс хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх талаар баримталж буй бодлоготой уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах, олгох зээлийн болон барьцааны гэрээний загвар, маягыг батлах, сангаас олгосон зээлийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийг бүрдүүлэн хөтлөх, зохистой харилцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд сангийн дансыг түр хугацаанд хааж, сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэх саналыг төсөв, санхүүгийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч иргэдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сангийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, энэ журмын 2.7-д заасан санхүүжилтээр сургалт зохион байгуулан ажилладаг байгууллага юм.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/521 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Иргэний тухай хууль, Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, Иргэний тухай хууль, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шарын гол сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шарын гол сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,813.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	130,110.70	237,516.20	107,405.50
Авлага	305,265.20	203,920.50	(101,344.70)
Нийт хөрөнгө	435,376.00	441,436.70	6,060.70
Өр төлбөр	1,703.20	1,703.20	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	433,672.80	439,733.50	6,060.70
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	435,376.00	441,436.70	6,060.70

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 237,516,2 мянган төгрөгт хүрч 107,405.5 мянган төгрөгөөр өссөн нь зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс 108,476.2 мянган төгрөгийн орлого орж үйл ажиллагааны зардал 1,070.7 мянган төгрөгөөр зарцуулснаас шалтгаалсан байна.

Зээлийн авлага дансны үлдэгдэл 203,920.5 мянган төгрөг болж 101,344.7 мянган төгрөгөөр буурсан нь зээлийн хүүгийн авлага 7,131.5 мянган төгрөг нэмэгдэж, 108,476.2 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 439,733.5 мянган төгрөг болж 6,060.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 120,000.0 мянган төгрөгөөр тооцож, санхүүжих эх үүсвэрийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг хэвээр баталсан байна.

Төсвийн дунд хугацааны хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр тайлант оны батлагдсан зээл нийт 108,476.2 мянган төгрөг Үүнд: бараа үйлчилгээний зардлын 1,070.7 мянган төгрөг эзэлж байна.

Гүйцэтгэлээр тайлант онд зээлийн эргэн төлөлтөөс 108,476.2 мянган төгрөг орсон үйл ажиллагааны зардалд 1,070.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 1,070.7 мянган төгрөг буюу 0,41 хувьтай байгаа нь тайлант онд зээл авах хоршоодийн зээлийн шалгуур хангаагүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Хөтөлбөр Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	259,006.40	1,070.70	(257,935.70)	0.41
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	5,000.00	1,070.70	(3,929.30)	21.41
1.2	83111- Сум хөгжүүлэх	254,006.40	-	254,006.40	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж

заасны дагуу Шарын гол сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Шарын гол сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/35 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 660,0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажиллаж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 4,122.9 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	4,122.9	1	4,122.9	100
Нийт дүн	1	4,122.9	1	4,122.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй байна.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	/мянган төгрөгөөр/														
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо		Дүн				
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	Тоо	Дүн	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/												
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт				Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-